

**БАТЛАВ:** УЛААНБААТАР ХОТ  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:


  
М.МӨНХӨӨ  
9020030414 6021646






**БАТЛАВ:**  
“И ЖИ ӨҮ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ:

Л.БУЛГАН

**ЦАХИЛГААН РЕДУКТОРТОЙ ДУ700-Н ГАГНАДАГ БӨМБӨЛГӨН ХААЛТ  
ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

Дугаар № 

20  оны -р сарын 

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө нөгөө талаас “И ЖИ ӨҮ” ХХК-ийг төлөөлж захирал Л.Булган /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр Бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь заалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл**

1.1 Нийлүүлэгч нь “Цахилгаан редуктортой ДУ700-н бөмбөлгөн хаалт” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан нэр төрөл, тоо хэмжээ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

**Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа**

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажсанаас хойш **45** хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

**Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл**

- 3.1 Энэ гэрээний нийт үнэ 192,885,000 /Нэг зуун ерэн хоёр сая найман зуун наян таван мянга/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх, тээврийн зардал, НӨАТ бүгд шингэсэн болно.
- 3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.3 Барааг хүлээлгэн өгсний дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 90 хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Голомт банкны 2015117846 тоот дансанд шилжүүлнэ.

Захиалагч тал



1/4

Нийлүүлэгч тал



## Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна.
- 4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.3 Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Зуухан цехийн дарга Э.Ариунболд хариуцан ажиллана. Утас-99727172
- 4.5 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг “И ЖИ ӨҮ” ХХК-ийн захирал Л.Булган хариуцан ажиллана. Утас-88110803.

### Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед эвдэрч гэмтэхээс хамгаалсан сав, баглаа, боодолтой байна.
- 5.3 Нийлүүлэгч нь хуучин хаалтыг авч шинэ хаалтыг гагнан угсарч, суурилуулж, дулаалга хийж өгнө.
- 5.4 Цахилгаан редукторыг алсын удирдлагад холбон, ажиллуулж туршиж хүлээлгэн өгнө./DCS-холбох/
- 5.5 Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.6 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.7 Нийлүүлэгчийн нийлүүлсэн барааны баталгаат хугацаа нь барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 12 сар байх бөгөөд баталгаат хугацаанд гарсан гэмтэл, доголдлыг захиалагчийн заасан хугацаанд үнэ төлбөргүй шуурхай засаж, сольж өгнө. Нийлүүлэх хаалт нь 2023 онд үйлдвэрлэгдсэн шинэ байна.
- 5.8 Барааг дараах баримт бичиг дагалдана.

Үүнд:

Барааны чанарын гэрчилгээ	3 хувь
Хаалтын ашиглалтын заавар /монгол хэл дээр/	3 хувь
Техникийн паспорт	3 хувь
Хаалтын танилцуулга, фото зураг	3 хувь



### **Зургаа. Бараа хүлээн авах**

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна

### **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцөлүүд хэсэгчлэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.
- 7.3 Давагдашгүй хүчин зүйл гэдгийг зөвхөн Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим батална.

### **Найм. Гэрээг цуцлах үндэслэл**

- 8.1 Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцална.
- 8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

### **Ес. Бусад нөхцөл**

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд нэг удаа сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр гэрээний хугацааг сунгах ба нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.



**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Э.МӨНХЖАРГАЛ

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ



Ө.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Г.БАТТУЛГА

ЗУУХАН ЦЕХИЙН  
ДАРГА



Э.АРИУНБОЛД

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН



Г.САРУУЛ

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:  
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН



Ш.ГАНТУЛГА

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**



Л.БУЛГАН

Д.МӨНХЦЭЦЭГ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар  
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251  
РД: 6021646

Хаяг: БГД 3-р хороо Авто ХАБ төв 401 тоот  
Утас: 77124848, 88110803  
РД: 5571863

Захиалагч тал



4/4

Нийлүүлэгч тал

